ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Эрүүл мэндийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДОА-2026/075/НА-СТА-ТШЗ**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Чойбалсан хот<br>2026 он | Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br>Тэргүүлэх аудитор: Б.Болортуул<br>Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn<br>Аудитын менежер: Д.Нармандах<br>Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Я.Зориг<br>Утас: 7058-4207, Цахим хаяг: zorigya@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт........................................................................................3-4

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл....................................................5-10

3. Аудитын илрүүлэлт ..........................................................................................................11

4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.................................................................13

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын дээд байгууллагын Олон Улсын Стандарт |
| АЗДТГ | Аймгийн Засаг даргын Тамгын газар |
| ДОА | Дорнод аймаг |
| НА | Нийцлийн аудит |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| ОНТ | Орон нутгийн төсөв |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ҮОМШӨ | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2026.02.24 № 84

танай ________ -ны № ________ -т

ДОРНОД АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА Ч.ОЮУНАА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Эрүүл мэндийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудал**

Дорнод аймгийн Эрүүл мэндийн газар нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилго, 15 зорилтын хүрээнд 74 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг аймгийн Засаг дарга 95.1 хувиар дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

2125020210

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **299,883,348.38** | **295,866,582.38** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 00.00 | 00.00 |
| **311** | **Кассанд байгаа бэлэн мөнгө** | 00.00 | 00.00 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 00.00 | 00.00 |
| **33** | **АВЛАГА** | 00.00 | 00.00 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | 00.00 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 299,883,348.38 | 295,866,582.38 |
| **351** | **Түүхий эд материал** | 279,460,279.34 | 295,866,582.38 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 25,208,768.47 | 32,280,768.47 |
| 35130 | Эм боох материал | 254,251,510.87 | 263,585,813.91 |
| **354** | **Хангамжийн материал** | 20,423,069.04 | 00.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 9,102,865.00 | 00.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 1,981,404.04 | 00.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 9,338,800.00 | 00.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,327,570,962.22** | **3,197,112,961.71** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 3,327,570,962.22 | 3,197,112,961.71 |
| **392** | **Биет хөрөнгө** | 3,225,720,962.22 | 3,095,262,961.71 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,375,639,488.00 | 2,375,639,488.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -98,114,994.79 | -102,442,129.14 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 349,379,988.00 | 349,379,988.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -177,025,473.24 | -238,391,169.74 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 1,215,550,071.69 | 1,246,158,853.96 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -486,360,873.47 | -573,222,950.92 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 129,406,748.70 | 117,525,373.70 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -84,790,211.36 | -79,957,949.26 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 309,547,636.00 | 289,803,032.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -307,511,417.31 | -289,229,574.89 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 101,850,000.00 | 101,850,000.00 |
| 39301 | Програм хангамж | 1,520,000.00 | 1,520,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,520,000.00 | -1,520,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 101,850,000.00 | 101,850,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **3,627,454,310.60** | **3,492,979,544.09** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **00.00** | **7,879,989.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 00.00 | 7,879,989.00 |
| **413** | **Өглөг** | 00.00 | 7,879,989.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 00.00 | 7,879,989.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 00.00 | 3,409,720.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 00.00 | 4,470,269.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **3,627,454,310.60** | **3,485,099,555.09** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 3,627,454,310.60 | 3,485,099,555.09 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 644,255,978.44 | 644,255,978.44 |
| 51101 | Өмч: - төрийн | 542,405,978.44 | 542,405,978.44 |
| 51102 | - хувийн | 101,850,000.00 | 101,850,000.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 2,983,198,332.16 | 2,840,843,576.65 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 2,983,198,332.16 | 2,983,198,332.16 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -142,354,755.51 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **3,627,454,310.60** | **3,492,979,544.09** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **5,374,989,991.57** | **4,749,141,409.84** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **00.00** | **00.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,325,891,780.57** | **854,894,577.90** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,325,891,780.57 | 854,894,577.90 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **4,049,098,211.00** | **3,894,246,831.94** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 3,232,869,913.00 | 3,240,283,884.70 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 3,232,869,913.00 | 3,240,283,884.70 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 816,228,298.00 | 653,962,947.24 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 38,228,280.00 | 110,978,960.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 720,115,318.00 | 453,979,601.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 55,439,700.00 | 88,604,386.24 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2,445,000.00 | 400,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **5,587,144,848.61** | **4,891,496,165.35** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **5,587,144,848.61** | **4,891,496,165.35** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 3,642,219,115.76 | 3,063,451,147.94 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,032,510,900.07 | 1,227,034,412.44 |
| 210101 | Үндсэн цалин | 613,818,880.50 | 637,907,017.90 |
| 210102 | Нэмэгдэл | 293,264,765.26 | 354,036,515.53 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 43,451,760.50 | 122,966,465.11 |
| 210104 | Урамшуулал | 81,975,493.81 | 112,124,413.90 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 128,633,061.60 | 153,441,723.59 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 87,466,863.87 | 102,688,169.59 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,722,423.10 | 12,685,064.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,662,044.76 | 6,345,833.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 5,312,429.64 | 6,346,733.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 19,469,300.23 | 25,375,924.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 31,563,326.25 | 32,457,389.94 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,760,052.31 | 8,137,456.01 |
| 210302 | Түлш, халаалт | 14,809,949.94 | 16,916,399.93 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 8,993,324.00 | 7,403,534.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 69,359,267.00 | 62,175,263.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,282,099.00 | 13,537,338.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 56,042,175.00 | 39,922,644.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 988,722.00 | 767,282.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 381,700.00 | 556,100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,664,571.00 | 7,391,899.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 1,120,070,281.66 | 712,682,544.86 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,109,345,471.66 | 711,178,544.86 |
| 210502 | Хоол, хүнс | 10,378,810.00 | 1,456,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 346,000.00 | 48,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 47,552,002.04 | 11,686,069.04 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 38,212,952.04 | 371,260.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 00.00 | 730,700.00 |
| 210604 | Урсгал засвар | 9,339,050.00 | 10,584,109.04 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 56,196,800.00 | 88,720,400.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 56,196,800.00 | 88,720,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 8,755,674.00 | 74,863,574.56 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний | 1,600,000.00 | 67,478,525.56 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,032,300.00 | 925,200.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 225,712.00 | 237,112.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 132,000.00 | 165,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 5,115,162.00 | 5,407,237.00 |
| 210807 | Газрын төлбөр | 650,500.00 | 650,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,147,577,803.14 | 700,389,770.51 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 850,988,675.23 | 422,634,470.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 953,554.00 | 00.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 295,635,573.91 | 277,755,300.51 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,944,925,732.85 | 1,828,045,017.41 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,688,243,613.00 | 1,784,977,554.40 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 759,565,213.00 | 911,651,374.40 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 925,528,400.00 | 872,236,180.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,150,000.00 | 1,090,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 256,682,119.85 | 43,067,463.01 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 256,682,119.85 | 43,067,463.01 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-212,154,857.04** | **-142,354,755.51** |
| **145** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | 00.00 | 00.00 |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 303,503,424.32 | 00.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 303,503,424.32 | 00.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -303,503,424.32 | 00.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-515,658,281.36** | **-142,354,755.51** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **4,176,960,211.00** | **3,894,246,831.94** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **00.00** | **00.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **00.00** | **00.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **4,176,960,211.00** | **3,894,246,831.94** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 3,232,869,913.00 | 3,240,283,884.70 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 3,232,869,913.00 | 3,240,283,884.70 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 944,090,298.00 | 653,962,947.24 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 38,228,280.00 | 110,978,960.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 720,115,318.00 | 453,979,601.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 55,439,700.00 | 88,604,386.24 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 130,307,000.00 | 400,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **4,156,070,211.00** | **3,894,246,831.94** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **4,156,070,211.00** | **3,894,246,831.94** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,211,144,478.15** | **2,067,291,814.53** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,039,147,148.05 | 1,227,034,412.44 |
| 210101 | Үндсэн цалин | 620,455,128.48 | 635,804,893.90 |
| 210102 | Нэмэгдэл | 293,264,765.26 | 356,138,639.53 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 43,451,760.50 | 122,966,465.11 |
| 210104 | Урамшуулал | 81,975,493.81 | 112,124,413.90 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 128,633,061.60 | 153,441,723.59 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 87,466,863.87 | 102,688,169.59 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,722,423.10 | 12,685,064.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,662,044.76 | 6,345,833.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 5,312,429.64 | 6,346,733.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 19,469,300.23 | 25,375,924.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 31,563,326.25 | 32,117,389.94 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,760,052.31 | 8,137,456.01 |
| 210302 | Түлш, халаалт | 14,809,949.94 | 16,576,399.93 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 8,993,324.00 | 7,403,534.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 50,907,768.00 | 55,404,543.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 8,800,440.00 | 10,453,938.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 38,242,695.00 | 40,092,644.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 988,722.00 | 698,062.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 736,700.00 | 556,100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,139,211.00 | 3,603,799.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2105** | **Нормативт зардал** | 13,858,897.00 | 51,369,687.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 253,947.00 | 23,603,070.00 |
| 210502 | Хоол, хүнс | 13,383,550.00 | 27,691,917.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 221,400.00 | 74,700.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 15,258,349.00 | 4,354,100.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 7,849,049.00 | 00.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 124,600.00 | 704,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,284,700.00 | 3,650,100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 56,196,800.00 | 85,386,800.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 56,196,800.00 | 85,386,800.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 8,755,674.00 | 73,757,005.56 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,600,000.00 | 67,478,525.56 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,032,300.00 | 925,200.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 225,712.00 | 237,112.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 132,000.00 | 165,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 5,115,162.00 | 4,300,668.00 |
| 210807 | Газрын төлбөр | 650,500.00 | 650,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 866,823,454.25 | 384,426,153.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 865,869,900.25 | 384,426,153.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 953,554.00 | 00.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,944,925,732.85** | **1,826,955,017.41** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,688,243,613.00 | 1,783,887,554.40 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 759,565,213.00 | 911,651,374.40 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 925,528,400.00 | 872,236,180.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,150,000.00 | 00.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 256,682,119.85 | 43,067,463.01 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 256,682,119.85 | 43,067,463.01 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **20,890,000.00** | **00.00** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **4** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)** | **00.00** | **00.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **20,890,000.00** | **00.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **20,890,000.00** | **00.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 20,890,000.00 | 00.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 20,890,000.00 | 00.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-20,890,000.00** | **00.00** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 560,705,978.44 | 00.00 | 3,953,940,314.65 | 4,514,646,293.09 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **560,705,978.44** | **00.00** | **3,953,940,314.65** | 4,514,646,293.09 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -455,083,701.13 | -455,083,701.13 |
| C08 | **2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **644,255,978.44** | **00.00** | **2,983,198,332.16** | 3,627,454,310.60 |
| D01 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **644,255,978.44** | **00.00** | **2,983,198,332.16** | 3,627,454,310.60 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **644,255,978.44** | **00.00** | **2,983,198,332.16** | 3,627,454,310.60 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -142,354,755.51 | -142,354,755.51 |
| D09 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **644,255,978.44** | **00.00** | **2,840,843,576.65** | 3,485,099,555.09 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 3,273,413,500.0 | 3,197,616,504.7 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 3,273,413,500.0 | 3,197,616,504.7 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,455,029,800.0 | 1,413,728,950.3 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,205,136,200.0 | 1,183,011,599.8 |
| 210101 | Үндсэн цалин | 722,920,500.0 | 635,804,893.9 |
| 210102 | Нэмэгдэл | 327,521,500.0 | 312,115,826.9 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 63,395,600.0 | 122,966,465.1 |
| 210104 | Урамшуулал | 91,298,600.0 | 112,124,413.9 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 152,479,200.0 | 148,068,421.6 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 103,445,100.0 | 99,034,321.6 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,255,200.0 | 12,255,200.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,130,900.0 | 6,130,900.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 6,131,800.0 | 6,131,800.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 24,516,200.0 | 24,516,200.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 34,729,800.0 | 32,117,389.9 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,086,900.0 | 8,137,456.0 |
| 210302 | Түлш, халаалт | 16,576,400.0 | 16,576,399.9 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 9,066,500.0 | 7,403,534.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 33,902,800.0 | 28,487,399.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,245,200.0 | 2,839,438.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 24,942,800.0 | 20,790,000.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,124,700.0 | 698,062.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 660,200.0 | 556,100.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,929,900.0 | 3,603,799.0 |
| **2105** | **Нормативт зардал** | 2,248,300.0 | 866,700.0 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,049,600.0 | 792,000.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 198,700.0 | 74,700.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,910,800.0 | 1,369,600.0 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,112,200.0 | 704,000.0 |
| 210604 | Урсгал засвар | 798,600.0 | 665,600.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 10,749,500.0 | 6,792,800.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 10,749,500.0 | 6,792,800.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 6,936,800.0 | 6,278,480.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,036,700.0 | 925,200.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 237,500.0 | 237,112.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 165,000.0 | 165,000.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,847,100.0 | 4,300,668.0 |
| 210807 | Газрын төлбөр | 650,500.0 | 650,500.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 6,936,400.0 | 6,736,560.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,936,400.0 | 6,736,560.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,818,383,700.0 | 1,783,887,554.4 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,818,383,700.0 | 1,783,887,554.4 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 946,147,400.0 | 911,651,374.4 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 872,236,300.0 | 872,236,180.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 4,876,166,200.0 | 3,240,283,884.7 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 4,876,166,200.0 | 3,240,283,884.7 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 4,876,166,200.0 | 3,240,283,884.7 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 46.0 | 42.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.0 | 1.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 38.0 | 34.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 7.0 | 7.0 |
| 620004 | Гэрээт ажилтан | - | - |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **653,562,864.2** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **653,562,864.2** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 653,562,864.2 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 44,022,812.7 |
| 210102 | Нэмэгдэл | 44,022,812.7 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 5,373,302.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 3,653,848.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 429,864.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 214,933.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 214,933.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 859,724.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 26,917,144.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 7,614,500.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 19,302,644.0 |
| **2105** | **Нормативт зардал** | 50,502,987.0 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 22,811,070.0 |
| 210502 | Хоол, хүнс | 27,691,917.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,984,500.0 |
| 210604 | Урсгал засвар | 2,984,500.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 78,594,000.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 78,594,000.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 67,478,525.6 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 67,478,525.6 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 377,689,593.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 377,689,593.0 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 653,962,947.2 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 653,962,947.2 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 110,978,960.0 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 453,979,601.0 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 88,604,386.2 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 400,000.0 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 58,920.2 мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад залруулах бичилт хийлгэсэн.

*Залруулсан алдаа:*

1. Эрүүл мэндийн сайдын А/310 дугаар тушаалаар үнэ төлбөргүй ирсэн 707.6 сая төгрөгийн тоног төхөөрөмж /зүрхний цахилгаан бичлэгийн аппарат/-ийг дутуу бүртгэсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага"-ыг заавал бүртгэнэ, 14.2-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ давхар бичилтийн аргаар хөтөлнө" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, толилуулга, оршин байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар нийт 25,290.8 мянган төгрөгийн 4 зөрчил[2] илэрснээс, 15,519.2 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 9,771.6 сая төгрөгийн 1 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүллээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 25,290.8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 19,468.8 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

### 3.1 Төлбөрийн акт

1. Газрын 2 албан хаагчийн түр орлон гүйцэтгэсний нэмэгдэлд 1,971.2 мянган төгрөгийг илүү бодож олгосон байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам"-ын 2.2 дахь "Энэ журмын 2.1-д заасан түр орлон гүйцэтгэх хугацаа нь 6 сараас дээш үргэлжлэх бол түр орлон гүйцэтгэж байгаа албан тушаалын цалингийн 40 хүртэл хувийг түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид олгоно." гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Албан хаагчдын улирлын үр дүнгийн урамшууллаас гадна сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх уралдаанд идэвх санаачилгатай ажилласан 32 албан хаагчдад үндсэн цалингийн 30 хувийн мөнгөн шагнал 13.5 сая төгрөгийг хавтгайруулан олгосон байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1-ийн "15.1.Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:", 15.1.3. "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;" гэсэн хориглох заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 3.2 Албан шаардлага

Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5-д заасан аймаг, сумын эрүүл мэндийн байгууллагын 12 албан хаагчид 3 болон 5 жилийн тэтгэмжийн 97.7 сая төгрөгийг олгохдоо 9.8 сая төгрөгийн ХХОАТ суутгаагүй олгосон байна. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д "Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно:", 6.3.1-д "цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого", 7 дугаар зүйлийн 7.1-д "Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна:" 7.1.1-д "ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого", 25 дугаар зүйлийн 25.6-д "*Суутган төлөгч нь албан татвар төлөгчийн орлогоос суутган авсан албан татварыг энэ хуулийн 25.2-т зааснаас бусад тохиолдолд дараа сарын 10-ны өдрийн дотор холбогдох төсөвт шилжүүлнэ.*", Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.19 дэх *"суутган төлөгч" гэж тухайн төрлийн татварын хуулийн дагуу татвар төлөгчийн төлөх татварыг суутгаж, төсөвт шилжүүлэх, тайлагнах үүрэг бүхий этгээдийг;"* гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нэмэлт дансны зарцуулалттай холбоотой

*Илрүүлэлт:* Нэмэлт дансаар орж, гарч байгаа аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан хөтөлбөр, арга хэмжээнүүдийн батлагдсан төсөв дэх зардлын задаргаа хэтэрхий ерөнхий дүнгээр батлагдаж, зарим хөтөлбөр, төсөл арга хэмжээний зардлыг хооронд нь гүйлгэн зарцуулсан байна.

*Өгсөн зөвлөмж*: Хөтөлбөр, арга хэмжээний төсвийн задаргааг сайжруулж, зардлыг зориулалтын дагуу зарцуулж, зардал хооронд гүйлгэхгүй байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасныг хэрэгжүүлж ажиллах. Зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

# 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

## Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Эрүүл мэндийн сайдын А/310 дугаар тушаалаар үнэ төлбөргүй ирсэн 707.6 сая төгрөгийн бараа материал /зүрхний цахилгаан бичлэгийн аппарат/-ыг дутуу бүртгэсэн байна. | 1 | 58,920.2 | | | | | 1 | 58,920.2 | | | | |
| **Дүн** | **1** | **58,920.2** | | | | | **1** | **58,920.2** | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

*/мянган төгрөгөөр/*

| *Зөрчлийн товч утга* | *Нийт зөрчил* | | *Үүнээс* | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | *Төлбөрийн акт* | | *Албан шаардлага* | | *Зөвлөмж* | | *Хариуцлага тооцуулах албан шаардлага* | | *Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал* | |
| | *Тоо* | *Дүн* | *Тоо* | *Дүн* | *Тоо* | *Дүн* | *Тоо* | *Дүн* | *Тоо* | *Албан тушаалтны тоо* | *Тоо* | *Дүн* |
| Түр орлон гүйцэтгэсний нэмэгдлийг 2 ТАХ-д илүү олгосон | *1* | *1,971.2* | *1* | *1,971.2* | - | - | - | - | - | - | - | - |
| Албан хаагчдад үндсэн цалингийн 30 хувийн мөнгөн шагналыг хавтгайруулан олгосон | *1* | *13,548.0* | *1* | *13,548.0* | - | - | - | - | - | - | - | - |
| 3, 5 жилийн нэмэгдэлд ХХОАТ суутгаагүй | *1* | *9,771.6* | | | *1* | *9,771.6* | | | | | | |
| Нэмэлтээр орж ирсэн хөтөлбөр, арга хэмжээний зардлын задаргаа хангалтгүй, зардал хооронд гүйлгэсэн | *1* | - | - | - | - | - | *1* | - | - | - | - | - |
| ***Дүн*** | ***4*** | ***25,290.8*** | ***2*** | ***15,519.2*** | ***1*** | ***9,771.6*** | ***1*** | ***1*** | ***-*** | ***-*** | ***-*** | ***-*** |